

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Tom. XXXVI (386)

2013

(77-82)

САДАН ТӨРЛИЙН ХАМААТ ХЭЛЛЭГТ ИЛРЭХ
ЯПОН МОНГОЛ ХҮНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГ

Ц.Онон *

Хэл бол үндэстэн угсаатны соёлыг тээгч бөгөөд хэлэнд туссан соёлын үзэгдлийг хэл соёл гэдэг. “Хэл шинжлэл, соёл судлал хоёр ойртсон нь тохиолдлын бус, амьдралаас, тэр дундаа гадаад хэл сурах, түүнийг заах аргаас үүдэлтэй”¹ ажээ.

Үнэхээр ч “гадаад хэлийг ард түмнүүдийн болоод соёл хоорондын харилцааны хэрэглүүр болгож сургах зорилтыг шийдвэрлэх гол арга зам нь сургалтыг тэр хэлээр ярьдаг ард түмний дотоод ертөнц, соёлыг судлах ажилтай нягт холбох явдал юм. Хүмүүсийг харийн хэлээр харилцаж сургах хэцүү гэдэг нь ойлгомжтой, учир нь харилцаа гэдэг нь зөвхөн хэлээр төдийгүй хэлний бус харилцааны хэрэглүүрүүдийг өргөн хэрэглэж байж хэрэгждэг. Түүний үр дүн нь хэлний мэдлэгээс гадна харилцааны нөхцөл, соёл, хэвшсэн хэллэгүүдийг ашиглах ёс, аялга гээд олон зүйлээс хамаардаг. Хэлний бэрхшээлээс гадна соёлын үл ойлголцлыг даван туулах нь илүү ярвигтай”².

Хэл ба соёлын харилцаа холбооны асуудлыг эрдэмтэд үндэстний соёлын бүрэлдэхүүн хэсэг хэмээгээд тэрхүү үндэстний соёлоор дамжин буй онцлогийг олж харахын тулд тухайн үндэстний сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзлийг таньж мэдэх нь гадаад хэл сурч буйн чухал ач холбогдолтой тал гэж үздэг агаад түүнийг нь судлан тайлбарлах чухал сурвалж, хэрэглэгдэхүүн нь зүйр цэцэн үг, өвөрмөц хэллэг, оноосон нэр зэрэг тогтвортой хэллэгүүд байдаг. Тиймээс энэхүү өгүүлэлдээ орчуулгын хичээлийн эх хэрэглэгдэхүүнд давтамжтай илэрдэг япон, монгол хэлний садан төрлийн хамаат нэртэй

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Гадаад хэлний тэнхим

¹) Б.Азжая, “Үндэстний сэтгэлгээ зүйр үгээр илрэх нь”, Гадаад хэл заах аргазүй, Улаанбаатар, 2012, 137-р тал

²) Ш.Туяа, “Гадаад хэлний сургалт ба соёл хоорондын тухай асуудал”, Гадаад хэл заах аргазүй, Улаанбаатар, 2012, 13-р тал

холбогдох зарим тогтвортой хэллэгийг сонгон авч, түүний утга, үндэстний сэтгэлгээний онцлогийг ажиглахыг зорилоо.

Садан төрлийн хамаат япон тогтвортой хэллэгийн жишээ баримтаас үзвэл, тэнд хадам, бэр, хүргэн орсон хэллэг, ялангуяа хадам ээж болон бэрийн харьцааг харуулсан нь олонтоо тааралдаж байна.

Жишээ нь, 嫁と姑, 犬と猿 (Хадам бэр, нохой сармагчин)
小姑鬼千匹 (Хадам дүү нэг байсан ч мянган чөтгөртэй адил)
嫁の朝立ち娘の夕立ち (Бэр өглөө гардаг, охин орой гардаг)
嫁は下から婿は上から (Бэрийг дороос, хүргэнийг дээрээс)
秋茄子嫁に食わすな (Намрын хашийг бэрдээ бүү идүүл)
嫁の皿 (Бэрийн таваг)
姑の涙汁 (Хадмын нулимс)
姑走り (Хадам ээж гүйх)

Эмэгтэй хүн гэрлэхээрээ эр нөхрийн гэрт очдог бөгөөд тэнд байх хадам ээж болоод нөхрийн эгч дүү нарын орон зай бэрийн хувьд хамгийн таагүй зүйл байдгийг дээрх хэллэгүүдээс харж болно. Хоорондоо эв найргүй, түнжин муутай гэсэн санааны зүйрлэл нь япон хэлнээ “*нохой сармагчин хоёр*”, “*хадам бэр хоёр*” байна. Мөн бэр хүн төрсөн гэртээ харихаар хадмынхаас гарахдаа өглөө эртлэн баяр хөөртэйгээр гардаг бол, эргээд хадмын гэр лүү явахдаа төдий л яаралгүй, дурамжхан орой гардаг гэдгийг хоёр дахь хэлцээс харж болно.

Мөн бэрдээ хандах хадам ээжийн дээрэнгүй, харамч, хахир байдлыг “*бэрийг дороос, хүргэнийг дээрээс*”, “*Намрын хашийг бэрдээ бүү идүүл*”, “*Бэрийн таваг*” “*Хадмын нулимс*” гэх мэт хэллэгээс харж болох байна. Япончууд эртнээс, бэрийг өөрийн гэрээс доод гаралтай айлаас буулгаж, илүү язгуур угсаатай айлын хүүг хүргэнээр угтан авах нь зохимжтой гэж үздэг байж. Ийнхүү бэр буулгахдаа ихэд судлан шинжиж, хүүгээсээ насаар ах охиныг сонгодог байсан нь айл гэрийн өөдлөн дэвжих нь эм хүний үйлээс шалтгаална гэж үздэгтэй холбоотой бөгөөд энэ нь “*悪妻は百年の不作-Эм муу бол зуун жил ургац алдах*”, “*姉女房は身代の薬-Эгч эхнэр гэрийн анагаах эм*” зэрэг хэллэгээс ч ажиглагддаг. Эдгээр хэллэг нь бэр ажилч хичээнгүй, төлөв даруу байх ёстой бөгөөд арчаагүй залхуу хүн таарвал нэг үеэр зогсохгүй, хойтдын үр удамдаа ч халгаатай гэсэн үзэлт, мөн эр нөхрөөсөө насаар ах эхнэр түүнийхээ сайн түшиг тулгуур болж, эр хүний хөнгөн, үрэлгэн байдлыг засаж залруулах, гэр бүлийн эв найрыг хадгалах чухал хүчин зүйл гэсэн санааг агуулж байна.

Ширээн дээрх хоолноосоо улирлыг мэдэрдэг япончуудын хувьд намар боловсорч гүйцдэг ногооны дотроос хамгийн амттай, хүн бүрийн дурладаг нь хаш байдаг. Гэтэл

хадам ээжүүд түүнийг бэрдээ өгөхийг төдий л таашаадаггүй бөгөөд нимгэн хавтгай жижиг тавганд тун бага хоол өгдөг байснаас үүдэн нэгэн төрлийн жижиг хавтгай хясааг “*Бэрийн тавгаг*” хэмээн нэрийджээ. Мөн өдгөө ч, тун ховор, маш бага зүйлийг “*Хадмын нулимс шиг*” хэмээн бэрийнхээ төлөө урсгах хадам эхийн нулимсны хэмжээтэй зүйрлэн хэлдэг байна. Эдгээр нь хадмаа үзэх бэр хүний илэрхийлэл гэж харж болохоор байгаа бөгөөд үүний эсрэгээр, намрын хаш хэдий амттай ч сэрүүн чанартай байдаг тул биед сөрөг нөлөөтэй, их идэх нь эрүүл мэндэд сайнгүй, нялуун бус хатуу шулуунаар хандах нь цаашдынх нь амьдралд хэрэгтэй тул дээрх хэллэгүүд нь хадам эхийн хал нь гаднаа хайр нь дотроо байдлыг илэрхийлж байгаа гэх тайлбар ч байдаг. Ямартай ч, хадам бэрийн харьцаа нь өнөө хир ээдрээтэй хэвээр бөгөөд хадмын саналаар гэр бүлээ цуцлуулах буюу салахыг “*Хадам гүйх*” гэж хэлдэг.

Бэртэй харьцуулбал, япон хэлний хүргэнтэй холбоотой тогтвортой хэллэгт сөрөг үнэлэмж бараг үгүй. Энэ нь эр хүн хэдий муу байсан ч эм хүнээс дээр гэж үздэгтэй холбоотой.

Сонирхолтой нь, япон хэлнээ 婿入り-хүргэн орох, 婿入り婚-хүргэн орох гэрлэлт, 婿取り娘-хүргэн авах охингэсэн хэллэг байна. Японд айлын ууган хүү гал голомтоо залган, өв хөрөнгө, аж ахуйгаа хариуцан явдаг. Харин голомт залгах хүүгүй айл өөрийн өв хөрөнгө, эрхлэх аж ахуй болон өөрсдийн овгийг үлдээхийн тулд гаднаас хүргэн авдаг байж. Ялангуяа тариачны тосгон дотроо гэрлэдэг байсан эрт үед ийнхүү *хүргэн орох гэрлэлт* нь элбэг байсан бөгөөд өнөө ч айлын ууган хүү биш л бол ганц охинтой айлд хүргэн орж, өөрийн овгоо эхнэрийнхээ овгоор солих хүн байдаг. Хүнтэй суусан эмэгтэй хүн нөхрийнхөө овгийг авдаг хэдий ч дээрх тохиолдолд хүргэн нь овгоо солих бөгөөд охиныг *хүргэн авах охин* гэнэ. Ийнхүү гал голомтыг нь залгахаар гэрт нь ирж байгаа хүргэнийг хүндэтгэн, сайнаар хүлээж авах нь мэдээж тул хүргэнд хандсан сөрөг үнэлэмж ховор байх нь аргагүй мэт.

Гэхдээ хүргэний зүгээс гарсан байж болох 粉糠三合あったら婿に行くな-*Будааны хивэг гурван атга байгаа бол хүргэн орсоны хэрэггүй* гэсэн хэллэг байна. Будааны хивэг гэдэг нь цагаан будааг боловсруулах үед гарах нунтаг зүйл бөгөөд хивэг гурван атга гэдэг нь өчүүхэн бага хөрөнгө гэсэн утга. Ингээд үзвэл, эр хүн өчүүхэн төдий ч хамаагүй, хурааж цуглуулсан зүйл байгаа л бол айлд хүргэн орох хэрэггүй, бие даан өөрийн гэр бүлийг өөрөө бий болгох нь чухал хэмээн уг хэлц хэллэгийг тайлж болохоор байгаа ба хэдий айлд орж, голомт залгах болж байгаа ч, өөрийн гэртээ байгаа шиг байж чадахгүй, хүний эрхээр байх нь тийм ч таатай зүйл биш шүү гэсэн санааг агуулж байна.

Тэгвэл, *хүүтэй бол охинтой, охинтой бол хүүтэй* гэж үздэг монголчуудын тогтвортой хэллэгт хадам, бэр, хүргэнийг дараах байдлаар илэрхийлсэн байна.

Хаданд харвасан сум харьд өгсөн бэр адил.

Чулуу цохьсон талаа, бэр очсон талаа.

Сая буусан бэр цэгц

Нуурт буусан нугас цэгц

Саглагар мод талын чимэг

Сайн бэр гэрийн чимэг.

Өршөөлт сайн эзэн улсын эрдэнэ

Элбэрэлт сайн бэр гэрийн эрдэнэ.

Хад сайтын үнэг бардам

Хадам сайтын хүргэн бардам.

Хазгар хүргэн хадамсаг

Муу эм төрхөмсөг.

Хүргэн хүү хүчтэй

Хүзүүний мах амттай.

Хүргэн хүүгийн хүзүү бөх

Хүрэл чулууны амь бөх

Хүний малын нуруу бөх.

Жишээ болгон авсан дээрх хэллэгээс харахад, монголчуудын бэр хүргэнээ болон хадмаа үзэх сэтгэлгээ япончуудынхаас ялгарах онцлогтой байна.

Өргөн уудам тал нутагт нүүдэллэн аж төрж ирсэн монголчуудын хувьд хүн хүч хамгаас чухал. Хэдий цусан болоод ясан төрлөөрөө холбогдоогүй ч гэлээ бэр болоод хүргэнээ хадмууд нь насаар ахмадын хувьд, үр хүүхэдтэй нь ханилан ураг төрлийн холбоотой болж байгаагийн хувьд дотно хандан, төрүүлсэн үр шигээ хайрладаг.

Хадамд гарсан бүсгүй хүн эр нөхрөө дагаж ирсэн цагаас тэр айлын нэгэн бүрэн эрхт гишүүн нь болж, өөрийн чадах бүх зүйл, хайр энэрлээ нөхөр, хадам эцэг эхдээ үзүүлэн, хөгшдийг асран тойлж, ахуй амьдралаа байнга өөд татан явах хүнд үүргийг хүлээнэ. Эцэг эхээсээ холдон, харьд очсон бэр хүний ажил хүнд хэцүү, бэрх байдаг ч нэгэнт бусдын эхнэр болж очсон л бол хадам талдаа уусан шингэдэг гэсэн санааг “Хаданд харвасан сум харьд өгсөн бэр адил”, “Чулуу шидсэн талаа, бэр очсон талаа” хэмээнбайгаа онолгүй хаданд тусан хугарч хагаран үлдсэн сум болон шидсэн чулуутай зүйрлэсэн байна. Тиймээс ч монголчууд харьд одож буй охиноо хүний газар цэгцтэй, хэрсүү болгоомжтой, аятай эвтэй суухыг сануулж ирсэн нь удаах хэллэг болон төр хуримын сургаалын чанартай олон дуунд тусгалаа олсон байдаг.

Мөн бэр хүн хичнээн ухаалаг, үнэнч сайхан сэтгэлтэй, хэдий чинээ ажилч хичээнгүй байна, хадмууд нь төдий чинээ бэрээ хүндлэн хайрладаг нь *уран бэр, ачлалт бэр, цэцэн бэр* хэмээх хэллэг ном зохиол, үлгэр домогтолонтоо гардагаас, мөн олны хайрлан үздэг цэцгийг “*бэр цэцэг*” хэмээн нэрийдсэнээс нь харж болохоос гадна “*Сайн бэр гэрийн чимэг*” хэмээсэн нь монголчуудын нүүдэлчин амьдралын онцлогтой холбоотой эмэгтэй хүн гэрийн доторх ажлыг эрхлэн гүйцэтгэх бөгөөд айл гэрийн өнгө зүс, өөдлөх сайжрахын тэмдэг нь гэрийн эзэгтэй байдаг гэсэн санаа, ухаарлын илрэл болжээ. Түүнчлэн “*Элбэрэлт сайн бэр гэрийн эрдэнэ*” гэж байгаачлан, элбэрэл журамтай энгийн төв байх нь бэр хүний нандин сайн чанар, монголчуудын хувьд сайн сайхны тухай тогтсон жишиг хэмжүүр болно³. Ийнхүү сайн бэрийг эрдэнэ болон гэрийн чимэгтэй адилтгасан нь зүйрлэж буй зүйл нь өөр боловч гаргах санаа ухагдахуун нь өмнө дурдсан япон хэллэгтэй таарч байна.

“*Уул усны ойр нь, ураг төрлийн хол нь*” хэмээн үзэж, хүргэнийхтэйгээ хаяа нийлээд буугаад байдаггүй атал, монгол хэлнээ “*Хүргэн хүү хүчтэй, хүзүүний мах амттай*” хэмээсэн хэллэг байгаа нь сонирхол татаж байна. Энэхүү хэллэгийн санаа нь хадамдаа таалагдахын тулд хэцүү бэрх ямар ч ажил байсан хийхээр гүйх хүргэний хичээл зүтгэлийг, амттай ч дан хар хатуу махтай мөлжихөд хэцүү хүзүүний ястай зүйрлэжээ гэж үзэж болох агаад улмаар уг санаагаа “*Хүргэн хүүгийн хүзүү бөх, хүрэл чулууны амь бөх, хүний малын нуруу бөх*” хэмээн “хүн-байгаль-мал” гэсэн нүүдэллэн аж төрөх амьдралын хэв маягтайгаа холбождэлгэрүүлэн илэрхийлсэн байна. Мөн гэрлэсэн эр хүн хадам тал руугаа, эм хүн төрсөн гэр лүүгээ гүйгээд байх нь тийм ч таатай зүйл бус гэдгийг “*Хазгар хүргэн хадамсаг, муу эм төрхөмсөг*” хэмээн егөөдсөн аясаар тодорхойлсон байна.

Ийнхүү *хадам, бэр, хүргэн* хэмээх садан төрлийн хамаат нэртэй холбогдох зарим нэр, тогтвортой хэллэгээс үзвэл, хадам болон бэрийн харьцааг харуулсан сөрөг үнэлэмж бүхий хэллэг япон хэлнээ цөөнгүй байхад монгол хэлнээ төдийлөн ажиглагдахгүй байна. Харин айл гэрийн өөдлөн дэвжих нь бэр буюу эхнэр хүнээс шалтгаалнагэх санаа хоёр хэлнээ нийтлэг байгаа бөгөөд энд нэг адил санаа ухагдахууныг өөр өөр зүйлээр адилтган илэрхийлсэн байгаа нь тухайн үндэстний нийгмийн ахуй соёл, уламжлалт ёс заншилтай холбоотой гэж үзэж болох байна.

³) Энхжаргал.С, “Монгол хэлний тогтвортой нэгжийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн талаас судалсан нь-Монгол ардын “Ертөнцийн гурав”-ын жишээн дээр-”, Хэлбичгийн ухаанаар докторын зэрэг горилсон ганц сэдэвт бүтээл, Уб., 2012,

НОМЗҮЙ

1. Аззаяа.Б, “Үндэсний сэтгэлгээ зүйр үгээр илрэх нь”, Гадаад хэл заах аргазүй, Уб, 2012.
2. Аким. Г, “Монгол зүйр цэцэн үгийн тайлбар толь”. Уб., 2001.
3. Баянсан.Ж, “Хэл, соёл, үндэстний сэтгэлгээ” Уб., 2002.
4. Гаадамба.М,Цэрэнсодном.Д, “Монгол аман зохиолын дээж”, Уб., 1967
5. Туяа.Ш, “Гадаад хэлний сургалт ба соёл хоорондын тухай асуудалд”, Гадаад хэл заах аргазүй, Уб., 2012.
6. Цэвэл.Я, “Монгол хэлний товч тайлбар толь”, Уб, 1966.
7. Цэрэнсодном. Д, Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, Уб., 2011
8. Чулуунбаатар.Л, Онон.Ц, “Япон монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” Уб., 2010.
9. Baker. M, “In Other Words: A coursebook on translation” London and NewYork, 2002.
10. “故事ことわざ・慣用句辞典”三省堂編修所, 1999.
11. “ことわざ辞典”岩波書店, 2000.

SUMMARY

The soul of the word is its meaning that reveals the development of the real world through the language which is used for. A word has a definite meaning, in fact, but can be determined by more different meanings based on many factories like language development, process of word usage and social cultural changes. One of these features is focused on idioms.

We attempted to analyze the national mentality from some proper nouns and idioms which are formed by a word, used “Relative” through this article.

According to the idioms, it represents not only the negative evaluation in Mongolian language. But in Japanese, it represents negative evaluations.